



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.18 компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.8 дахь хэсэг, Гүйцэтгэх захирал Х.Алтайгаас 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн “Хөлсөөр ажиллах гэрээний тухай” хүсэлт, мөн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн хүсэлт, Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01/02 дугаар албан бичиг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жадамба овогтой Цогтбаярыг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн компанийн Гүйцэтгэх захирал сонгох хүртэл түр хугацаанд Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.
2. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй байгуулах хөлсөөр ажиллах гэрээг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөрт багтаан Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулахыг Нэр дэвшүүлэх хороо (Н.Отгончимэг)-нд даалгасугай.
3. Гүйцэтгэх захирал Х.Алтайг түүний хүсэлтээр 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсөнтэй холбоотойгоор түүний үүрэгт ажлыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчид 2024 оны 1 дүгээр сарын 02-ны өдөр хүлээлцүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.
4. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн сарын үндсэн цалинг 5,200,000 төгрөгөөр тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Нарангэрэл)-д зөвшөөрсүгэй.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР